



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар A/26

Модот

Газар эзэмших, эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нотариатын 2025 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн гэрээг судлан үзээд, Зоригт овогтой Түвшинжаргал (СУ79121971)-ийн эзэмшиж буй Цэнхэрмандал сумын 3 дугаар баг Согоот, Улаан чулуутад байрлах, 2321001897 нэгж талбарын дугаартай хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Онон овогтой Мөнгөндусал (СЙ86090214)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар эзэмшил, ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигч Онон овогтой Мөнгөндусал -д даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Я.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 24 -ний өдрийн А/82 тоот захирамжийн иргэн Г.Зоригт-д холбогдох хэсэг эзэмшлийн 000164357 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ